



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 11/38

Улаан-Уул


Хөрөнгө оруулалтын жагсаалтыг
батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 48 дугаар зүйлийн 48.1, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 11 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь;

1. Сумд үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын лиценз бүхий “Би Эс Ай” ХХК-ний гэрээний дагуу оруулах хөрөнгө оруулалтыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн эх үүсвэр дутагдалтай байгаа хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг зөвшөөрч жагсаалтыг хавсралтаар баталсугай.


2. Хөрөнгө оруулалтын ажлуудыг цаг хугацаа алдалгүй зохион байгуулахыг сумын Засаг дарга (Т.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГОНГОР

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус
11 дүгээр хуралдааны 2022 оны 10 дугаар сарын 19-ний
өдрийн 11/38 дугаар тогтоолын хавсралт



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДЭХ ХӨТӨЛБӨР,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Бодлогын баримт бичиг	Ажил арга хэмжээ	Төсөв /мян.төг/
1	2	3	6
1	<i>Зорилго 4.8. Ээлтэй төлөвлөлт - Эрсдэлгүй амьдрал.</i> Зорилт 4.8.1. Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж байгаа “Сумын төвийн шинэчлэл” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, иргэдийг ая тухтай тохилог орчинд амьдрах нөхцлийг сайжруулна.	Сумын төвийн явган зам, орчны тохижилтын ажил	40,100.0
2	Зорилт 4.8.4. Сумын нутаг дэвсгэр дэх авто замын аюулгүй байдлыг хангаж, тэмдэг тэмдэглээтэй болгоно. Зорилт 7.1 Иргэдийн аюулгүй байдлын түвшинг нэмэгдүүлнэ.	Улсын чанартай авто зам дагуу хийгдэх гэрэлтүүлгийн засварын ажил	14,900.0
ДҮН			55,000.0

---oOo---